

ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙ ГЭМТ ЯВДЛЫН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ, ТҮҮНИЙ ҮНДСЭН ШИНЖ

THE ORIGIN AND DEVELOPMENT OF ORGANIZED CRIME, ITS MAIN CHARACTERISTICS

Баттөмөр Мөнхбаяр*

Баянхонгор аймгийн цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа, Дотоод хэргийн их сургуулийн докторант

Pol. Col. Munkhbayar Battumur, Chief of Bayankhongor Province Police Department, Ph.D Candidate, University of Internal Affairs

*хариуцлагатай зохиогч: munkhbayar.bmbr@gmail.com

Хураангуй: Зохион байгуулалттай гэмт хэрэг нь орчин үеийн эрүүгийн эрх зүйн болон криминологийн судалгааны чухал сэдэв бөгөөд тухайн улсын үндэсний аюулгүй байдал, хууль дээдлэх ёс, нийгмийн шударга ёсны тогтолцоонд ноцтой хохирол учруулдаг гэмт хэргийн цогц хэлбэрт тооцогддог. Уг өгүүлэлд зохион байгуулалттай гэмт хэргийн үүсэл, түүхэн хувьсал, түүний онолын үндэс болон олон улсын эрх зүйн баримт бичигт хэрхэн тусгалаа олж буй байдалд дүн шинжилгээ хийв.

Зохион байгуулалттай гэмт хэрэг нь XX зууны дунд үеэс олон улсын хэмжээнд хурдацтай өргөжиж, хил дамнасан гэмт хэргийн сүлжээ, эдийн засгийн хуулийн эсрэг үйл ажиллагаа, авлига, хүний болон мансууруулах бодисын наймаа зэрэг төрлөөр илрэх болсон. Үүнийг даган олон улсын эрх зүйн орчинд НҮБ-ын “Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тухай конвенц” (2000 он) зэрэг гол баримт бичгүүд батлагдсан нь зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд эрх зүйн суурь тогтоосон юм.

Монгол Улсад зохион байгуулалттай гэмт хэрэг нь зах зээлийн шилжилтийн үеэс эхлэн нэмэгдэж, 1990-ээд оны эхэн үеэс улс төр, эдийн засгийн орчны тогтворгүй байдал, хууль тогтоомжийн сул байдал, хууль сахиулах байгууллагын чадавхгүй байдлыг далимдуулан өргөжсөн. Иймд зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг олон улсын стандарттай нийцүүлэн боловсронгуй болгох, хууль сахиулах байгууллагуудын уялдаа холбоо, мэдээллийн солилцоог сайжруулах, шүүх, прокурор, цагдаагийн байгууллагуудын хараат бус, мэргэжлийн тогтолцоог бэхжүүлэх шаардлагатай байна.

Энэхүү бүтцийн талаар бүрэн ойлгохын тулд түүхчлэх, нэгтгэн дүгнэх (синтез), задлан шинжлэх (анализ), адилтгах (аналог), харьцуулах зэрэг аргуудыг ашиглан судалгааг хийж, “Мафи”-ийн үүсэл зүй тогтлыг хамгийн тодоор харуулах Италийн мафи, улс орны улс төр, эдийн засгийн тогтолцоонд орж хэрхэн хүчирхэгждэг болохыг АНУ, ОХУ мафийн түүхээр төлөөлөн харуулах нь оновчтой гэж үзлээ.

Abstract: Organized crime is a critical subject in contemporary criminal law and criminological research, being regarded as a complex form of criminal activity that causes serious harm to national security, the rule of law, and social justice systems. This article analyzes the origins, historical development, and theoretical foundations of organized crime, as well as its reflection in international legal instruments.



Дотоод Асуудлын
Университет



Since the mid-20th century, organized crime has rapidly expanded on a global scale, manifesting through transnational criminal networks, economic crimes, corruption, human trafficking, and drug smuggling. In response, key international legal documents such as the United Nations Convention against Transnational Organized Crime (2000) have been adopted, establishing a legal framework for combating such crimes globally.

In Mongolia, organized crime began to proliferate during the transition to a market economy. Since the early 1990s, political and economic instability, weak legal frameworks, and the limited capacity of law enforcement institutions have created conditions for its growth. Therefore, aligning Mongolia's criminal legal regulations with international standards, enhancing inter-agency cooperation and information exchange, and strengthening the independence and professionalism of the judiciary, prosecution, and police are essential steps in addressing this issue.

To fully understand the structure and nature of organized crime, this study employs methods such as historical analysis, synthesis, deconstruction, analogy, and comparative analysis. The research identifies the Italian mafia as a prime example illustrating the origin and pattern of mafia-type organizations, while also examining how similar criminal structures gained power by infiltrating political and economic systems in countries like the United States and Russia.

Түлхүүр үгс: Зохион байгуулалттай гэмт явдал, мафи, Оросын холбооны улс, Дотоод явдлын яам, Америкийн нэгдсэн улс.

Keywords: Organized crime, mafia, Russian Federation, Ministry of Internal Affairs, United States.

Удиртгал

ЗБГЯ нь нийгмийн хөгжлийн үр хөврөлд дунд дахь гэмт явдлын хөгжлийн үр дүн бөгөөд дэлхий дахины болон тодорхой нэг улс орны нийгэм, улс төр, эдийн засгийн гүн гүнзгий өөрчлөлт нь тухайн нөхцөлд бүрэлдсэн нийгмийн тогтолцоог илэрхийлэхийн зэрэгцээ тухайн үед үүсэн гэмт явдлын хөгжил, хөдөлгөөний холбоо сүлбээний тогтолцоог харуулахын зэрэгцээ тодорхой төрлийн зарим гэмт үйл ажиллагаа яваандаа дангаар ноёрхох хандлагатай болдгийг гэрчилдэг (Нарангэрэл, 1991, хууд. 1).

Зохион байгуулалттай гэмт явдал эрх зүйн салбарт харьцангуй шинэ тутам судлагдахуун бөгөөд зохион байгуулалттай гэмт хэрэгтэй гүйцэтгэх ажлаар тэмцэх асуудлаар хууль зүйн доктор М.Ганболд нэг сэдэвт бүтээлийн хэмжээнд, хууль зүйн доктор З.Төрмандах гүйцэтгэх ажлаар тэмцэх асуудлыг өөрийн судлан буй сэдвийн хүрээнд хөндөж тавьсан

байдаг. Түүнчлэн шинжлэх ухааны доктор, профессор Ж.Болдбаатар, Хууль зүйн доктор, профессор Д.Адъяабазар, Д.Мягмарцэрэн нарын бүтээлд зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд гүйцэтгэх ажил чухал болохыг хөндсөн байна.

Эрх зүйн шинжлэх ухааны танин мэдэхүй, судалгааны үндсэн аргууд судалгааны арга зүйн үндсийг бүрдүүлсэн түүхчлэх, нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх, адилтгах, харьцуулах гэх зэрэг аргуудыг тодорхой аргачлалын дагуу түүнчлэн төр хууль цаазын түүх бусад шинжлэх ухааны чиглэлээр туурвигдсан гадаад, дотоодын эрдэмтдийн бүтээлүүд, Монгол Улсын Их Хурал, Цагдаагийн ерөнхий газраас баталсан хууль, эрх зүйн актыг судалгаандаа ашиглалаа.

Судалгааны ажлын хамрах хүрээг ОХУ, АНУ, Итали улсын мафийн үйл ажиллагааг харьцуулан судалгаа хийсэн болно.

Энэхүү судалгааны зорилго нь

дэлхийн улс орнууд дахь зохион байгуулалттай гэмт явдлын үүсэл, зохион байгуулалттай бүлэг, байгууллага, түүний онцлог шинжийг харьцуулан судалж, өөрийн орны нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, сайжруулах талаар санал дэвшүүлэхэд оршино.

Үндсэн хэсэг

Нэг: Зохион байгуулалттай гэмт явдлын үүсэл, хөгжил

Италийн мафи: Анхны зохион байгуулалттай гэмт бүлгийг Италийн мафи (Mafia) гэж үздэг. Газар тариалангийн орон Италийг олон зууны туршид харийнхан (Грек, Ромчууд, Византе, Араб, Норман, Бурбонам, Франц г.м.) удирдаж, эрх баригчдын эрх ашгийг хамгаалж байснаас ард түмэн үгүйрэн хоосорч, эдийн засаг уналтад орсны зэрэгцээ жирийн иргэд цөхөрч байсан тэр л үед Италийн Сицилид хэсэг бүлэг тариачид нэгдэн дарангуйлагчдын эсрэг зэвсэг барин тэмцэх болсон байна. Ард иргэд ч дарангуйллаас чөлөөлөгдөх, эрх баригчдаас хамгаалагдах цорын ганц зам нь Мафи хэмээн нэрлэгдэх зэвсэглэсэн тариачид гэж үзэн тэднийг дэмжих болжээ.

Мафи гэдэг нэр томьёоны үүсэл нь Сицилийн ард түмэн Францийн эзлэн түрэмгийлэгчдийн эсрэг тэмцэн боссон тэрхүү түүхэн цаг үе буюу 1863 онд Джузеппи Ризоттогийн бүтээсэн “I mafiusi di la Vicaria (мафиозо)” дуулалт бүжгэн жүжигт шоронгийн хоригдлууд “Morte Francia, Italia anela” буюу “Франц сөнө, Итали амьсгаа ав” гэж дуулдаг. Энэхүү дуулалт бүжгэн жүжиг төрсний дараагаас дарангуйллын эсрэг зэвсэглэн боссон тэмцэгчдийг Morte Francia, Italia anela гэх үгсийн эхний үсгүүдийг нийлүүлэн товчилсон үсгээр “MAFIA” гэсэн нэрших болсон байна.

“Мафия” гэдэг үгийг 1868 оны тайлбар тольд: “Хэн нэгний өөртөө

ашиг хонжоо олох гэсэн үйлдэл” гэж тодорхойлсон бол, Оксфордын нэвтэрхий тольд: “Сицилийн иргэдийн хууль бус үйлдлүүд ба тэдний хүч хэрэглэх байдал” гэж тодорхойлжээ (Mafia Noun, n.d.).

Харин криминологийн толь бичигт: “Мафи гэх нэрийг зөвхөн ядуучууд болон дарлагдагсдыг хамгаалах, арилжаа наймаанд төлөөлөн оролцох ажиллагаанд ашиглаж байсаар бидний мэдэх мафи үүссэн бол, түүхэн цаг өнгөрөх тусам мафи нь улам бүр гэмт байгууллагын шинжтэй болж өдийг хүрсэн” гэж тэмдэглэсэн байна.

Дайны дараах жилүүдэд Сицили нь бүхэлдээ мафийн суурьшлын бүс болсон ба үндэсний үзэл газар авч баян, ядуу гэлтгүй нэгдэн нийлж тэмцсэний дүнд 1947 онд Сицили автономит эрх олж авсан төдийгүй орон нутгийн хууль тогтоох хурлын сонгуульд Сицилийн 2 сая иргэний санал шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн байна.

Энэ үеэс Палермо аж үйлдвэр, худалдаа хөгжсөн хот болон хөгжиж эхэлсэн бөгөөд мафи нутаг дэвсгэр дээрээ буй аливаа бизнесийг хамгаалсныхаа төлөө мөнгө цуглуулдаг болсон бол, Сицилийн мафи Христиан-Ардчилсан намтай (ХАН) тохиролцон ХАН-ны сонгогчдын дэмжлэгийг баталгаатай хангаж ирсэн нь хөдөөгийн хуучин мафи өөрчлөгдөн хамгаалагчид болгон хувиргажээ. Мафийн зарим нь улс төрийн намын саналыг худалдаж авах мөнгө цуглуулагч, өрсөлдөгчдийг сүрдүүлэх, замаас нь зайлуулах зэрэг бохир ажлуудыг хийдэг болсон.

1948 оны сонгуулиар Италийн консерватив Засгийн Газар унаж, анх удаа зүүнийхэн засгийн эрхэнд гарсан төдийгүй 48 депутатын ихэнх нь мафийнхнаас бүрдсэн байв. ХАН сонгуульд ялалт байгуулснаар түүнийг дэмжиж, хамгаалж ялалт байгуулах нөхцөлийг хангасан Мафийн гол гэр





ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠰᠠᠬᠢᠭᠣᠯᠠᠬᠤᠢ

бүлийнхэнд Палермод ачаа тээвэрлэх концесс олгосноор мафи хөгжих таатай нөхцөлийг бүрдүүлсэн төдийгүй тэднийг тодорхой албан тушаалд томилдог байсан ба тэрхүү албан тушаал нь мафид улс төрчдийн зүгээс халдашгүй байх бүрэн баталгаа, бохир бизнесээ цэцэглүүлэн хөгжүүлэх болжээ.

Гэр бүл тус бүр өөрийн бүтэц, харьяалах нутаг дэвсгэртэй, боссууд нь тэгш эрхтэй байв. Сицилийн мафийнхны гэр бүлүүд 150-аас илүү омгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулахын тулд Палермогийн 3 гэр бүл тутмыг төлөөлсөн 12 гишүүнээс бүрдсэн удирдах зөвлөл бүхий гэмт байгууллага “Купола” (Cupola) байгуулж, толгойлогчоор нь Сальватор Греко томилжээ. Мафийн гэр бүлүүд бүгд Куполад захирагдах ба Купола нь гэр бүлүүдийн хооронд үүссэн маргаан, хүчирхийллийг зохицуулах, бусад гэр бүлүүд нь Куполагийн гаргасан шийдвэрийг даган биелүүлэх үүрэгтэй байв.

1963 онд гэр бүлийн мафи хооронд мөргөлдөөнөөс үүдэлтэй ихээхэн хэмжээний аллага явагдсан ба тэр үед цагдаа нар ч мөн алагдаж байв. Италийн Засгийн газар хариу арга хэмжээ авч олон тооны зэвсэг хураан, 1900 хүнийг баривчилж 250 орчим мафийн толгойлогчид мөрдөлт явуулж ихэнхийг шоронд суулгажээ. Мафийн зарим хэсгийг Италийн хойд хэсэгт нутаг заан суулгасан нь мафи баттай түшиц газраа байгуулах нөхцөлийг бүрдүүлсэн бол, нэг хэсэг нь гадаад улс руу оргон зугтжээ.

Ийнхүү Купола устсан ч 1975 онд дахин байгуулагдсан ба мафийн бүтэц өөрчлөгдөж мансууруулах зүйл, зэвсгийн худалдаа, рэкет хийж үйл ажиллагааны хүрээ тэлж аллага үйлдэхийг үндсэн аргаа болгосон Ла Коза Ностра /La Cosa Nostra/ хэмээн

нэрлэгдсэн диктатур бүхий мафи үүсжээ (Алтанбагана, 2013, хууд. 134). 1975 онд Туркийн зохион байгуулалттай бүлэг Сицилийн мафид хагас боловсруулсан морфины гол бэлтгэн нийлүүлэгч болгосон бол, газрын дундад тэнгисийг эзэлсэн сүлжээ бүхий неаполитаны Камморро Силчилчүүдтэй хүчээ нэгтгэснээр мансууруулах бодисын худалдаанаас олох ашиг орлого нэмэгдэж, гарал үүслийг нь мэдэгдэхгүйгээр банкаар дамжуулан мөнгө угаах шаардлагатай болжээ. Тиймээс мафи улс төр, банк санхүүгийнхэнтэй холбоо тогтоож, АНУ-д героин гаргахыг зохион байгуулж, тэдэнд олсон ашгаасаа ногдол ашиг төлдөг болжээ.

Сицилийн мафийн зарим гэр бүл аж ахуй эрхлэгчид, үйлдвэрлэгч синдикат болсон бол, зарим нь Коза Нострагийн зэвсэгт хүчин **синдикат** хүчин болж, Сицилийн мафийнхан гэмт байгууллагаас **синдикат** буюу гэмт нийгэмлэгт шилжсэн төдийгүй үйл ажиллагааныхаа талбарыг өргөжүүлэн айлган сүрдүүлэх болон авлига өгөх замаар барилгын компани, банкнаас ашиг авах, улсын ашигтай гэрээ, контрактыг авах болжээ.

Америкийн мафи: Харин Америкийн мафийн хөгжлийн түүх нь тэд улс төр, эдийн засгийн тогтолцоонд хэрхэн нэвтэрснийг харуулдаг. 1840-д оноос Ирландчууд, дараа нь хятадууд, италичууд, орос болон баруун европын орнуудаас (цагаачдын олонх нь еврейчүүд) цагаачид олноор ирж суурьшсан ба тэдний дотор нутаг орноосоо буюу ял шийтгэлээс зугтсан гэмт бүлэглэлийнхэн ч мөн ирж суурьшиж байв.

1880 оноос аж үйлдвэржих явцтай зэрэгцэн үйлдвэрчний эвлэлийн тоо өссөн төдийгүй үйл ажиллагаа нь идэвхжиж байсантай холбоотойгоор орон нутгийн захиргааны

байгууллагын захиалгаар Ирланд, Итали, Еврей гаралтай гангаstrууд тэдний үйл ажиллагаанд саад учруулах, ажил хаялтыг зогсоохоор рэкетлэх (далайлган сүрдүүлэлт) болсон нь зохион байгуулалттай гэмт явдлын нэлээд ашигтай төрөл болж хөгжив.

Эдгээр гангаstrууд дотроос хамгийн харгис нь гэмт хэрэгтэн Италийн цагаачдаас бүрдсэн “La Mank Nera буюу Цэвэр гар” хэмээх бүлэг бөгөөд тэд бусдаас мөнгө нэхэж далайлган сүрдүүлэх буюу шантаачилсан (blackbail-хар захидал) захидал илгээж, шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд алахаар заналхийлэх, төлбөрөө удаашруулсан бол, гэр орон, эд хөрөнгөд халддаг байв.

1920-д оны үед АНУ-ын Үндсэн хуулийн 18 дугаар зүйлд “Согтууруулах ундааны зүйл үйлдвэрлэх тээвэрлэх, худалдан борлуулахыг хориглосон” зүйл заалтыг нэмэлт болгон оруулсан бөгөөд 1933 оны 12 дугаар сард уг зүйл заалтыг хүчингүй болгосон ч түүхэнд энэ үйл явдал “Хуурай хууль” гэж нэрлэгдэн үлджээ. Энэ үеэс согтууруулах ундааны хууль бус бизнесийн талбарыг гартаа авахын төлөө Итали, Ирланд гаралтай гангаstrуудын хооронд ширүүн тэмцэл өрнөж, эцэст нь гэмт бүлэглэлүүд АНУ-ыг газар зүйн байршлаар нь 27 дүүрэгт хуваан авч согтууруулах ундаа борлуулж, энэхүү хууль бус наймаанаас ихээхэн хөрөнгөжжээ.

1931 онд өмнөх зуунаас уламжлагдан Америкт хөгжсөн мафийг тус улсад төрж, өссөн өөрсдийн төрөлх нутаг, өв соёлын үнэт зүйлийг мэдэхгүй, Еврей-Америкийн, Итали-Америкийн зэрэг залуучууд орчин үеийн гэмт бүлэглэлүүдийг нэгтгэсэн зохион байгуулалттай гэмт бүтэц болох Үндэсний синдикат байгуулж өдгөө дэлхий нийтэд идэвхтэй үйл ажиллагаа

явуулсаар байна. “Синдикат” гэх үгийг Я.Цэвэл. Монгол Хэлний Товч Тайлбар Тольд (query.mn, 1966) “Зах зээл дээр ноёрхох, их ашиг олохын тулд байгуулагдсан капиталист үйлдвэрийн газруудын монополист нэгдэл” гэж тайлбарласан байна.

XIX зууны эцэс, XX зууны эхээр зохион байгуулалттай гэмт бүлэглэл, улс төр хоорондын нягт холбоо бүлэглэлийн идэвхжилээр бус, харин улс төрд байр сууриа бэхжүүлэх гэсэн улс төрчдийн санаачилгаар бүрэлдэн бий болжээ.

Сонгогдогч улс төрийн эрх мэдлийг авсны дараа өөрийнх нь төлөө санал өгөхөд ихээхэн хувь нэмрээ оруулсан этгээдүүдэд талархлаа илэрхийлж, хэрэгцээгээр нь тус хүргэх, **Тухайлбал**, Америкийн иргэн болох үйл явцыг түргэсгэх, зарим сонгогчдыг өөрт ашигтай албан тушаалд томилох зэргээр цагаачдыг ажлын байр, хамгаалалтаар хангах болжээ. Өгсөн саналыг хүчээр булаан авсны төлөө дээрэмчдийг тэтгэж, ивээлдээ авах энэхүү аргыг 1830 оноос XX зууныг дуустал Америкийн муж улсын удирдлагууд идэвхтэй ашигласаар ирсэн байна.

Улс төрийн ивээлийн энэ тогтолцоо өөрөөр хэлбэл, цагаачдын тоо, санал хоёр нь зүгээр нэг тэнцэтгэл бус, эрх мэдэл ба зохион байгуулалттай гэмт явдлын хоорондын харилцааг илэрхийлэх түлхүүр юм (Алтанбагана.Б, 2013, хууд. 155).

1941 он буюу АНУ дайны дараа эдийн засаг хурдацтай хөгжиж, энэ үед Нью-Йоркийн мафи үйлдвэрчний эвлэлийг хянаж байсан учраас далайн хөлөг онгоцны засварын ажилчид, ачааны машины жолооч нараар ажил хаяулах болон ажил хаялтыг зогсоолгож байсан нь мафийнхны хувьд онцгой ашигтай байж, 1980 оны эх гэхэд Синдикат Нью-Йоркийн дэд





Хууль сахиулахуй

бүтцийг бараг бүхэлд нь хяналтдаа авсан байв.

1981 оноос АН-ын Засгийн газраас Рэкет болон Авлигатай тэмцэх тухай хууль батлан, зохион байгуулалттай гэмт явдалтай тууштай тэмцсэний үр дүнд Нью-Йоркийн 5 гэр бүлийн бүлэглэлийн дөрвийнх нь боссуудад ял шийтгэсэн нь мафийнхны хүчирхэг байдалд томоохон цохилт болж, өмнө нь нэг бүлэг 700-800 гишүүнтэй байсан бол, 1990 оны байдлаар мафийн нийт гишүүд 10.000 болтлоо буурсан гэсэн тооцоолол ч гарчээ (Пол Ланд, 2004, хууд. 65).

Нэгдсэн Үндэсний байгууллагын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас 2024 оны жилийн эцсээр гаргасан судалгаагаар жил бүр дэлхийн хэмжээнд ойролцоогоор 800 саяас 2 их наяд ам.доллар угааж байгаа нь улс орнуудын засгийн газрын хувьд тулгамдсан асуудлуудын нэг болоод байна (Ням-Очир, 2025, хууд. 2).

Нийгмийн хөгжлийг даган аливаа зүйлс хувьсан өөрчлөгддөг зүй тогтлын адилаар өдгөө мафийн үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдөн биржийн залилан мэхлэлт, интернэт садар самуун, кибер гэмт хэрэг, төлбөрийн карт хуурамчаар үйлдэх, банк, санхүүгийн залилан мэхлэлт, мөрийтэй тоглоом эрхлэх болсон ч хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын худалдаа эрхлэх нь ашигтай хэвээр байна.

Оросын мафи: Их гүрнүүд дотроос гэмт явдлын түвшин хамгийн өндөр байдаг улсын нэг нь ОХУ юм. ОХУ-ын ДЯЯ-ны мэдээллээр оросын зохион байгуулалттай гэмт бүлгүүд дэлхийн 26 улсад үйл ажиллагаа явуулж байна гэсэн бол, АНУ-ын ХМТ оросын мафи АНУ, ХБНГУ, Швейцар, Израйл, Турк, Голланд зэрэг 50 гаруй улсад идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг гэсэн байна (Пол Ланд, 2004, хууд. 92)

1917 оны Октябрын хувьсгалын дараагаас Москвагийн хар захаас үүсэлтэй гэмт бүлгийн гишүүд Сталины засаглалын үед засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн лагериудад олноор хоригдож байсан нь зохион байгуулалттай гэмт явдал буюу оросын мафи үүсэх хүчин зүйл болжээ. Зөвлөлт засаг эрүүгийн гэмт хэргийг улс төрийн гэмт хэргээс аюул багатай гэж үздэг байсан учир шоронд байсан гэмт хэрэгтнүүд зөвлөлт засгийн талаар таагүй үзэл бодолтой хүмүүсийг шоронгийн дарга нарт ховлон эрх баригчидтай нууцаар үгсэн хуйвалдан болсон байна.

Энэ л үеэс шоронгийнхны дунд хатуу журмаас бүрдсэн “Нэр төрийн” гэх өвөрмөц хууль бий болж, “Хуулийг хүлээн авсан хэн ч аливаа байгууллагад ажиллахгүй, эрх баригчидтай ямар нэг холбоо сүлбээгүй байх, хуулийг дагаж мөрдсөн хүн л гэмт хэргийн ертөнцөд өргөмжлөгдөн алдаршина” гэсэн заалт бүхий гэмт хэргийн ертөнцийн бичигдээгүй хууль бүрэлдэн томъёологдож, гэмт хэрэгтэн язгууртны дүр төрхийг бүрдүүлсэн нь ирээдүйн зохион байгуулалттай гэмт бүлгийн толгойлогчдыг төрүүлсэн юм.

1970-д оны үед өмгөөлөгч Константин Зимис коммунист намын бүтэц дэх авлигын тухай ярихдаа анх удаа Мафи нэр томъёог хэрэглэжээ. 1991 онд ЗСБНХУ задран унасантай зэрэгцэн зохион байгуулалттай гэмт явдал эрчимжсэн. Ил тод байдал, өөрчлөлт зэрэг нь зарим талаар ашигтай байсан ч ашиг олох зорилго бүхий чөлөөт худалдаанд үнэ, татвар, лиценз зэргээр ихээхэн чирэгдэл учруулж байснаас худалдаачид хахууль өгдөг хуучин тогтолцоонд эргэн орсон байна (Пол Ланд, 2004, хууд. 91).

Оросын мафийн дүр төрх 1990-ээд оноос буудалцах, хорлон сүйтгэх, айлган дарамталж хөрөнгө булаадаг

арга барилаасаа татгалзан, аль болох шийдвэр гаргах түвшнийхнийг сонгон онилж ажиллах, санхүүгийн луйвар хийх, голлох салбарт нөлөөгөө бэхжүүлэн өрсөлдөгчийнхөө талаар мэдээлэл цуглуулах, төвлөрсөн хөрөнгөөсөө шинээр албан ёсны фирм байгуулан татвар төлөх, шашин, буяны үйлсэд гар сунгах, хэл кино урлагт хөрөнгө оруулах гэх мэтээр албан ёсны дүр төрхтэй болжээ.

ОХУ-ын ДХЯ-ны зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх газрын дарга асан, одоогийн ОХУ-ын Думын депутат Александр Гуровын үзэж байгаагаар оросын мафи сүүлийн 20-25 жилд амьдрах чадвараараа италийн мафийн 200 жилийн түүхийг товчлон давтаж харуулж чадсан (Хориотой бүс сонин, 2012) гэжээ.

Хоёр. Зохион байгуулалттай гэмт явдлын үндсэн шинж

Зохион байгуулалттай гэмт бүтцийн олж буй хууль бус орлого нь инфляцыг хөөрөгдөх, нийгэм, улс төр, эдийн засгийн салбарт тэнцвэргүй байдлыг бий болгох замаар улс орныг хямралд оруулж, эдийн засгийн секторт сөргөөр нөлөөлдөг.

2005 онд АНУ-ын Үндэсний Тагнуулын байгууллагын Зөвлөлийн санаачилгаар зохион байгуулалттай гэмт явдлын талаар хийсэн судалгааны ажлын тайланд: “2020 он хүртэлх жилүүдэд байгалийн асар их баялагтай улс орнуудад зохион байгуулалттай гэмт явдал цэцэглэн хөгжих болно” хэмээн дурдсаныг өнөөгийн бодит байдалтай харьцуулан үзэхэд, үнэхээр сайн судалгаа хийсэн нь батлагдсан гэж үзэх үндэстэй байна.

Хэдийгээр зохион байгуулалттай гэмт бүтцийн ерөнхий шинж нь нийтлэг боловч, эрдэмтэн судлаачид зохион байгуулалттай гэмт бүтцийн үүсэх нөхцөл, шалтгаан, ямар гэмт хэрэг үйлдэхээр үүсэн зохион

байгуулагдсан, түүний дотоод бүтэц, гишүүний тоо, хүчин чадал, үйл ажиллагааны цар хүрээ, нийгэмд үзүүлэх нөлөөлөл, тогтвортой байдал, төр, түүний байгууллагуудаас хамгаалсан байдал зэрэг хөгжлийн үе шатны талаар зохих судалгаануудыг хийж, эдгээр шалгуураар хамгийн энгийн нэгжээс өндөр зохион байгуулалтад шилжсэн байдлаар нь тодорхой ангилалд оруулсан байна.

Тухайлбал, ОХУ-ын судлаач эрдэмтэн А.Н.Гуров нь зохион байгуулалттай гэмт явдлын үүсэл хөгжлийн үе шатыг үндэслэн:

1. Энгийн түвшний буюу гэмт бүлэг,
2. Дунд түвшний буюу гэмт бүлэглэл,
3. Дээд (өндөр) түвшний буюу гэмт байгууллага хэмээж, ийнхүү XIX зуунд зохион байгуулалттай гэмт хэрэг үйлддэг бүлэглэлүүдийг зохион байгуулалтын бүтцийн шинжээр дээрх гурван төрөлд ангилжээ.

Зохион байгуулалттай гэмт бүтцийн үүслийн түүхийг судлан үзэхэд, тэдгээр нь газар зүйн болон үндэстний зарчмаар зохион байгуулагддаг нь харагдана. ХХI зууны зохион байгуулалттай гэмт бүтцийг дээрх гурван ангилал хэвээр ч харин зохион байгуулалттай гэмт байгууллага болох “Мафи” нь улам хөгжин дараах төрөлтэй болсон байна. Энэ нь;

-удирдлагаас үл хамаарах тогтвортой бүтэц, зохион байгуулалтын нэгдэл буюу шинэ түвшний зохион байгуулалттай гэмт байгууллага;

-зах зээлд ноёрхох зорилгоор байгуулагдсан гэмт байгууллагуудын ноёрхогч нэгдэл корпорац;

-ХХ зууны шилдэг нээлтүүд интернэт болон бусад харилцаа холбооны хэрэгсэл, хиймэл оюун ухаан (AI) ашиглан богино хугацаанд





ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠰᠤᠬᠢᠭᠣᠯᠠᠬᠤ

криминал бизнес хийх гэмт хэргийн сүлжээ гэж шинэчлэгдэн эрэмбэлэгдэх болжээ.

Зохион байгуулалттай байгууллага: Гэмт этгээдүүд удирдагчаас хамааралтай нэгдлийг үйл ажиллагаандаа нийцсэн бүтэц, зохион байгуулалтаар сольсон бөгөөд зохион байгуулалттай гэмт явдлын шинэ түвшний үзэгдэл буюу гэмт бүлэглэлийн бүтэц хэн нэгнээс хамааралгүй (ялангуяа, толгойлогчоос) байгууллагын шинжийг агуулсан тогтвортой бүтэц, зохион байгуулалтын нэгдэл болон хөгжжээ.

Ийнхүү нэгдэл нь гол төлөв гэр бүлийн болон садан төрлийн холбоо хэлхээ, нутаг ус, овгийн харилцааны нэгдэлд суурилсан байх бөгөөд оршин тогтох үндсийг хадгалахын тулд гишүүдийг нэгтгэх тангараг болон бусад хатуу чанд зан үйлийг мөрдөх дэг жаяг, хариуцлага зэрэг дүрэм, журам бүхий бүтэц зохион байгуулалтыг үүсгэж дээд зэргээр нягтарсан бүлэглэл буюу байгууллага болон төлөвшдөг. Ийм байгууллага нь ихээхэн хэмжээний ашиг олох зорилготой учраас удирдагч, гүйцэтгэгч, дайчдаас гадна, өөрсдийн үйл ажиллагааг аливаа эрсдэлээс хамгаалах бүтэц, санхүү, дотоод хяналтыг хэрэгжүүлэгч дэд удирдлагаас бүрдсэн бүтэцтэй байх ажээ.

Зохион байгуулалттай гэмт нийгэмлэг (корпорац): Зохион байгуулалттай гэмт нийгэмлэг буюу корпорац нь гэмт үйлдлээ хэрэгжүүлэх болон хаацайлах зорилгоор төрийн албан тушаалтнуудыг авлига өгч байсан үе өнгөрч, харин засаглалд тэмүүлэх, төрийн механизмд нөлөө бүхий байр суурь эзлэхийг эрмэлзэх болсон нь тэд хөрөнгө санхүү, хүн хүчний хувьд илэрхий бэхэжсэн төдийгүй үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, нөлөөллийн түвшинд

мэдэгдэхүйц өөрчлөлт гарсныг харуулж байна.

Төрийн албан тушаалтныг элсүүлэх нь зардал чирэгдэлтэй, эрсдэлтэй алхам гэдгийг гэмт бүтцийн толгойлогчид ойлгож, хүний нөөцийн бодлогодоо илүү стратегич байр сууринаас хандах болж, өөрийн хүрээллийн залуучуудыг (үр хүүхэд, төрөл садан, бүлгийн гишүүд) төрийн тусгай албаны гадаад, дотоодын сургуулиудад сургах, улмаар шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын тодорхой албан тушаалд томилуулах зэрэгт илүү анхаарах болжээ (Бат-Эрдэнэ & Хосбаяр, 2011, хууд. 34). Тэд өөрийн төлөөний хүмүүсийг бүх шатны засаглалын байгууллагад оруулах, нам, төрөл бүрийн хөдөлгөөнийг болон сонгуульд нэр дэвшигчдийг санхүүжүүлэх, сонгуулийн санал худалдан авах замаар улс төрийн механизмыг гэмт үйл ажиллагаандаа ашиглах зорилгыг агуулдаг.

Зохион байгуулалттай гэмт бүтэц хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын тогтолцоонд өөрийн төлөөллийг байршуулан байр сууриа бэхжүүлэх замаар төрийн механизмыг гэмт зорилгодоо ашиглах нь нийгэмд тогтворгүй байдал үүсгэх, улс орныг бүхэлд нь хямралд оруулах зэргээр сөрөг үр дагавар хэмжээлшгүй их байх нь ойлгомжтой. Хууль зүйн утгаараа энэхүү үйлдэл нь Үндсэн хуулийн байгууламжид шууд бусаар халдаж буй гэмт үйлдэл юм.

Гэмт хэргийн сүлжээ: XX зууны шилдэг нээлтийн нэг хиймэл оюун ухаан (AI) нь дэлхий нийтийг орон зай, цаг хугацаанаас хамааралгүй даяаршлын шинэ хэлбэрт хөтөлсөн бөгөөд энэхүү шинжлэх ухаан, технологийн хувьслын шинэ боломжуудыг ч гэмт этгээдүүд олж

харсан юм. Тэд ямар нэг зохион байгуулалттай бүлэгт захирагдан тангараг өргөж, аюулгүй байдлаа хамгаалуулах алба ажиллуулах зэргээр нэгдэж нягтрахаас илүү богино хугацаанд криминал бизнес хийх сонирхолтой болсноор интернэт болон бусад харилцаа холбооны хэрэгсэл ашиглан сүлжээ үүсгэн ажиллахыг илүүтэй үзэх болжээ.

Зохион байгуулалттай гэмт үзэгдлийн орчин үеийн энэхүү шинэ түшн нь гэмт хэргийн сүлжээ бөгөөд гэмт этгээдүүд сүлжээг ашиглан асар их ашиг олох боломж олгодог хар тамхи, мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бодис, хүний болон зэвсгийн наймаа зэргийг богино хугацаанд улс дамнан үйлдсэнээр нэг талаас ашиг орлогоо үлэмж нэмэгдүүлэх, нөгөө талаар хууль, шүүхийн байгууллага, хариуцлагаас зайлсхийх зэрэг олон давуу байдлыг олж авах боломжийг сонгох болсон байна (Эрдэнэбат, 2012).

Судлаач Г.Эрдэнэбатын үзэж байгаагаар аль ч түвшний зохион байгуулалттай гэмт бүтэц нь дараах криминал шинжтэй байна. Эдгээрт:

1. Аливаа зохион байгуулалттай гэмт бүтэц нь ямагт өндөр ашиг орлогын төлөө байдаг,

2. Гэмт хэргийг нарийн төлөвлөж, илрэхгүйгээр удаан хугацаанд үргэлжлүүлэхийг эрмэлздэг,

3. Мэргэжлийн гэмт хэрэгтнүүдийг өөртөө нэгтгэсэн байдаг,

4. Үйл ажиллагааныхаа зорилгод нийцсэн тохирсон бүтэц, зохион байгуулалттай, авлига, хээл хахуулийн сүлжээгээр өөрсдийн аюулгүй байдал, ашиг орлогыг нөхцөлдүүлж байдаг гэсэн нь бодитой юм.

Зохион байгуулалттай гэмт явдал нь нийгмийн сөрөг үзэгдэл болохын хувьд үүсэж, хөгжих зүй тогтолд

захирагдахын сацуу тухайн орны улс төрийн байдал, нийгэм эдийн засгийн байгуулалт, үндэстний зан заншил, ёс суртахуун зэрэг олон хүчин зүйлээс хамаарч улс бүрийн болон бүс нутгийн онцлог шинжийг агуулан хувьсаж өөрчлөгдөж байдаг аж.

Тиймээс АНУ-ын судлаач эрдэмтэн Паул Лунде: "...Зохион байгуулалттай гэмт бүлэглэл нь ... бүтцийн хувьд улс орны болон орон нутгийн онцлог, үйл ажиллагааны цар хүрээ зэргээс хамаарч үйл ажиллагаандаа олон тооны арга хэрэгслийг ашигладаг зэргээр ондоо байх бөгөөд зах зээлийн өөрчлөлт, хууль зүйн орчин зэрэгт дээд зэргээр зохицож үйл ажиллагааны хэлбэрээ ямагт сайжруулдаг" (Паул Лунде, 2004, хууд. 9) гэж зохион байгуулалттай гэмт бүтцийн онцлог шинжийг тодорхойлсон байдаг.

XXI зуунд даяарчлал буюу нэгдмэл нэг дэлхий хэмээх үзэл баримтлал бий болсон цагаас дан ганц нэг улс орныг бус, дэлхий нийтийг цочроосон элдэв гэмт явдал тухайлбал, үндэстэн дамнаж үйлдэгддэг терроризм, зэвсгийн наймаа, хүн худалдаалах, цахим гэмт хэргүүд өргөжин тэлсээр байгаа ба гэмт хэрэг үйлдэж буй этгээдүүдийн хувьд ч зохион байгуулалтын нарийн бүтцэд шилжсэн байна.

Гарвал зүйн үүднээс үзвэл, **“Бүтэц”** гэх нэр томьёо нь **“дотоод байгуулалт”** гэж Монгол хэлний товч тайлбар толь (Цэвэл, хууд. 199) тайлбарласныг иш үндэс болговол, зохион байгуулалттай гэмт бүтэц бүрд оноосон нэршил нь тэдгээрийн дотоод зохион байгуулалтад үндэслэсэн байх бөгөөд XIX-XX зуунд зохион байгуулалттай гэмт хэрэг үйлддэг бүтцийг дээрх шинжүүдээр төрөлжүүлэн ангилж иржээ. Эдгээр ангилал нь тухайн цаг үеийнхээ нөхцөл байдалд тохирсон байсныг үгүйсгэх





ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠰᠤᠬᠢᠭᠠᠨ ᠰᠠᠬᠢᠭᠠᠨ ᠰᠠᠬᠢᠭᠠᠨ

аргагүй.

Зохион байгуулалттай гэмт явдлын бүтцийн зүй тогтол, чиг хандлагын түүхийг судлан үзэхэд, тэдгээр нь газар зүйн болон үндэстний зарчмаар зохион байгуулагддаг төдийгүй гэмт бүтцэд оноосон нэршил нь тэдгээрийн дотоод зохион байгуулалттай холбоотой байна.

Үүнээс үзвэл, зохион байгуулалттай гэмт хэрэг гэдэг нэршлийн зохион байгуулалттай гэдэг хоршоо үг нь тодорхой гэмт хэргийн төрөлд хамаарахгүй, харин гэмт хэрэг үйлдэж буй бүтцийн болон гэмт хэргийн ангилалд хамаатай байна.

Дүгнэлт

Ийнхүү мафийн мөн чанар нь гэмт хэрэг үйлдэх аргаар ихээхэн хэмжээний ашиг орлого олох явдал бөгөөд тэдний хөгжлийн түүхийг дараах байдлаар үечилж болохоор байна. Энэ нь:

-XIX зуунаас өмнөх үе буюу Мафи үүсэн бий болсон үе;

-XX зуун Мафи хүчээ авч хөгжиж, олон улсын шинж чанартай болон хөгжсөн үе;

-XXI зуун Мафи хэмээх байгууллагууд хөгжлийн шинэ шатанд (зохион байгуулалттай гэмт байгууллагууд төрөлжсөн сүлжээ бий болсон) гарсан үе хэмээн үечилж болохоор байна.

Дүгнэн үзвэл, эрх чөлөөний төлөөх тэмцлээс үүдэлтэй зэвсэглэсэн тариачид буюу босогчид болох мафийнхан хөгжлийнхөө явцад нийгэм, улс төрийн тогтолцоонд шургалан орсноор өөрийн гэсэн боловсон хүчинтэй, эдийн засгийн хувьд хүчирхэгжсэн улсын доторх улс болтлоо хөгжсөн нуугдмал хэлбэрт оршин тогтнох шинжийг агуулж байна.

Нуугдмал гэмт хэргийг олонх эрдэмтэд үндсэн хоёр хэсэгт хуваан ангилж байна. Нэгдүгээрт, “нууц далд”

гэмт хэрэг өөрөөр хэлбэл хууль сахиулах байгууллагад үйлдэгдсэн хэдий ч огт мэдэгдээгүй гэмт хэрэг. Хоёрдугаарт, “нуун дарагдуулсан” хууль сахиулах байгууллагад ямар нэг хэлбэрээр мэдэгдсэн боловч нэгдсэн тоо бүртгэлд ороогүй гэмт хэрэг (Мягмарцэрэн, 2014, хууд. 40) гэжээ. Зохион байгуулалттай гэмт бүтцээс энэ 2 хэлбэрээр гэмт хэргийг үйлдэхийн тулд эрх зүйн орчныг доройтуулах, хууль хүчний байгууллагын сул талыг ашиглах байдлаар илрэх хандлагатай.

ЗБГЯ-ын гэмт бүтцийн үйл ажиллагааны хамгийн дээд хэлбэр нь аливаа улс оронд үүсэн хямралт байдлыг ашиглан улс төрийн эрх мэдлийг авах буюу төрийн эрх мэдлийг хууль бусаар авах гэсэн гэмт хэрэг үйлдэх, цаашлаад манай улсад үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт явдал дамжин өнгөрөх суваг болж даамжрах, бусд улс орны гэмт санаархал буюу гаднын нөлөөллийг хүлээж авах эрсдэлт байдал үүсэх магадлалтай юм.

Тиймээс энэ гэмт явдалтай тэмцэхийн тулд хуулийн болон тусгай чиг үүргийн боловсон хүчнийг бэлтгэх сургуулиуд сургалтын хичээлийн хөтөлбөрт зохион байгуулалттай гэмт явдалтай тэмцэх ажлын үндсийг тусгаж, суралцагсдад тус гэмт явдлын ойлголтыг өгөх, хэрхэн тэмцэх, урьдчилан сэргийлж, таслан зогсоох арга зүйг заах, судалгаа, шинжилгээг өргөн, нарийвчилсан байдлаар хийх, практик ажилтнуудын чадавхыг сайжруулах, мөн орчин үеийн дэвшилтэд технологи (AI), арга, тактикийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх, түүнийг нотлох ажиллагаанд ашиглах эрх зүйн орчныг сайжруулах эрэлт хэрэгцээ зайлшгүй шаардлагатай байна.

Санал



Судалгааны ажлын явцад зохион байгуулалттай гэмт хэрэг, түүнтэй тэмцэх асуудлыг судалж, тодорхой үр дүнд хүрснээр бид дараах нэр томъёо, ухагдахуун, ойлголтыг шинээр тодорхойлж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх нэгжийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр дараах санал дэвшүүлж байна.

Үүнд:

1. Олон улсын гэмт хэрэг гэж тодорхойлогдсоноос бусад тодорхой хугацааны туршид ашиг олох зорилгоор зохион байгуулалттай гэмт бүлэг, бүлэглэлээс үйлдсэн ноцтой хор уршиг бүхий хүнд, ноцтой гэмт хэргийг **зохион байгуулалттай гэмт хэрэг** гэнэ гэсэн тодорхойлолт;

2. Гэмт хэрэг үйлдэх явдлыг орлогын эх үүсвэр болгох зорилгоор эмхлэн зохион байгуулагдах хүмүүсийн нэгдлийг **зохион байгуулалттай гэмт бүлэг** гэнэ гэсэн тодорхойлолт;

3. Эдийн засгийн өндөр ашиг олох, ашиг орлогоо нэмэгдүүлэх зорилго бүхий зохион байгуулалтад орсон нэгдлийг **зохион байгуулалттай гэмт бүлэглэл** гэнэ гэсэн тодорхойлолт;

4. Зохион байгуулалттай гэмт бүтцийг дотоод зохион байгуулалтын шинж чанараас хамаарч гэмт бүлэг, бүлэглэл, байгууллага гэж ангилна гэсэн тодорхойлолт;

5. Зохион байгуулалттай гэмт хэргийн онцлох шинжийг дараах байдлаар тодорхойлж байна.

- гэмт хэрэг үйлдэх нь орлогын гол эх үүсвэр болдог;

- эдийн засгийн хувьд бэхэжсэн;

- нийгэм, улс төрийн хүрээнд нөлөөллөө тогтоосон;

- гэмт хэрэг үйлдэхийн тулд авлига, хүчирхийллийг үндсэн зэвсгээ болгодог;

- гэмт үйл ажиллагаа нь уян хатан, далайцтай (гадаадад ч, дотоодод ч) байдлаар тогтмолжсон;

- дотоод бүтэц, зохион байгуулалтын хувьд нарийн чанд, иж бүрэн зохион байгуулагдсан;

- үйл ажиллагааны тодорхой чиглэлтэй ч нөхцөл байдалтай уялдуулан богино хугацаанд чиглэлээ өөрчлөх чадвартай байдлыг зохион байгуулалттай гэмт хэргийн онцлох гол шинжүүд гэж тодорхойлж байна.

6. Зохион байгуулалттай гэмт явдалтай тэмцэх практик байгууллагын бүтэц тогтолцоонд шинэчлэл (инженерчлэл) хийх шаардлагатай. Үүнд мөрдөх чиг үүргийн дагнасан байгууллагыг бий болгох. Энэ төрлийн гэмт явдал, суурь гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн байгууллагын боловсон хүчний мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх талаар хуулийн болон тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын сургалтын хөтөлбөрт зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тусгай курс, модуль, арга зүйн сургалтуудыг түлхүү оруулж, мэргэшсэн мөрдөгч, шинжээч, прокурор бэлтгэх.

7. Зохион байгуулалттай гэмт хэргийг “мэдээлэл олох, дүн шинжилгээ хийх, хариу сөрөг арга авах, илрүүлэн таслан зогсоох” өндөр нууцлалтай тогтолцоо юм гэдгийг ойлгож, практик үйл ажиллагаанд ашиглаж хэвшихэд түүний сүлжээ, хэлбэрийн талаар салбар хоорондын (эрүүгийн эрх зүй, криминологи, олон улсын харилцаа) шинжлэх ухаанч судалгаа хийх, эрсдэл, нөхцөл байдлыг тогтмол үнэлэх.

8. Зохион байгуулалттай гэмт явдалтай “дунд, урт хугацаа”-ны стратеги баримтлан тэмцэх, орчин үеийн хиймэл оюун ухаан (AI), дата анализ, дижитал мөрдлөгийн аргачлал зэргийг гэмт хэрэг илрүүлэх, нотлох ажиллагаанд ашиглах боломжийг бүрдүүлж, үүнийг дэмжсэн эрх зүйн



зохицуулалтыг боловсронгуй болгох. зэрэг болно.

Ашигласан материал

Нарангэрэл, С. (1991). *Зохион байгуулалттай гэмт явдал*.

Улаанбаатар: Хэвлэх үйлдвэр.

Mafia Noun. (n.d.). Retrieved from OxfordLearnersDictionaries.com: <https://www.oxfordlearnersdictionaries.com/definition/english/mafia?q=Mafia8>

Алтанбагана, Б. (2013). *Улс дамжсан зохион байгуулалттай гэмт хэрэг*. Улаанбаатар: МУИС-ийн Хууль зүйн сургууль.

Цэвэл.Я. (1966). *Монгол хэлний товч тайлбар толь*. Улаанбаатар: Хэвлэх үйлдэвэр, www.query.mn

Ням-Очир, Ц. (2025). Монгол улс дахь мөнгө угаах гэмт хэргийн өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ. *Хууль сахиулахуй сэтгүүл*, 41(1), 2-р тал. <https://doi.org/https://doi.org/10.63570/9v987415>

Пол Ланд. (2004). *Организованная преступность: Тайная история*

самого прибыльного бизнеса в мире. Москва.

Бат-Эрдэнэ.Б; Хосбаяр.П. (2011). Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх асуудал ба төрийн байгууллагын аюулгүй байдал. *Цагдаа судлал*(1), 34.

Эрдэнэбат, Г. (2012). Зохион байгуулалттай гэмт явдлын хандлага, тэмцлийн шинэ стратеги. *Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгамдаж буй асуудал: Олон улсын эрдэм шинжилгээний хурал*, (хууд. 67). Улаанбаатар.

Мягмарцэрэн, Д. (2014). Нуугдмал гэмт хэрэг: Ойлголт, шалтгаан, тооцоолол, өнөөгийн байдал. *Хууль сахиулахуй сэтгүүл*, 1(1), 40.

<https://doi.org/https://doi.org/10.63570/vfxbn377>

Хориотой бүс сонин. (2012, 12 11). *Оросын мафийн онцгой харгих ёс*. Retrieved from bolod.mn: <http://www.bolod.mn/News/92614.html>